# НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ “АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2024.06.05

Багахангай

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Хүрэх түвшин, үр дүн | Зарцуулах хөрөнгө | Хүрсэн түвшин, үр дүн | хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | 1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг:<br>а/байгууллагын албан ёсны цахим хуудас;<br>б/сошиал сувгууд;<br>в/дотоод сүлжээ;<br>г/хэвлэл мэдээллийн хэрэгсэл;<br>д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц;<br>е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх; | -Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх;<br>-Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх;<br>-Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших;<br>-Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. | Жилдээ | 7 хоног бүр цахим хуудсанд байршуулах | | Авлигатай тэмцэх газар, Сонгуулийн Ерөнхий хорооноос бэлтгэсэн “УИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийг хэрхэн сонгох бэ”, “УИХ-ын гишүүний хориглох үйл ажиллагаа”, “Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн анхаарах асуудал”, “Сонгуулийн ил тод байдал, сонгуульд оролцож буй талуудын зардал” видео контентыг дүүргийн bagakhangai.ub.gov.mn веб сайт, байгууллагын фейсбүүк хуудсуудаар сурталчлан ажиллалаа.<br>Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын үйлчилгээнд үнэлгээ өгөх "Товш" аппликэйшний талаар видео бичлэгийг дүүргийн www.bagakhangai.ub.gov.mn сайтад сурталчлан ажиллав. | 90 |
| | | 1.2.Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах | -Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх;<br>-Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх;<br>-Үр дүнг тооцсон байх. | Жилдээ | 2 өдөрлөг, 1 аян | | Хуулийн салбарын байгууллагуудын хууль сурталчлах, соён гэгээрүүлэх “Нээлттэй хаалганы өдөрлөг” –ийн арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Өдөрлөгөөр Авлигын эсрэг хуулийг сурталчлах 2 төрлийн гарын авлага бэлтгэн иргэдэд хүргэхээр бэлтгээд байна. | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1.3.Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах | -Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх;<br>-Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх;<br>-Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх;<br>-Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. | Сар бүр | 1200 ш гарын авлага тараах | | "Авлигагүй Багахангай" видео контент, постер шалгаруулах уралдааныг 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд зарлав.<br>Постер бүтээх уралдааны тавигдах шаардлагад<br>1.авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулсан, сурталчлан таниулсан, түүнд уриалсан байх,<br>2.авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх<br>3. JPG өргөтгөлтэй, сэдэвт тохирсон, шинэлэг бүтээлч, хуулбарлаагүй байх<br>Видео контент бүтээх уралдааны тавигдах шаардлагад<br>1.видео контентын зохиомж нь авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий байх<br>2.гар утас болон камераар бичсэн, бичлэг дуу дүрсний өндөр чанартай байх<br>3.үргэлжлэх хугацаа 3 хүртэл минут байх<br>4.ёс бус үг хэллэг агуулаагүй, нийгэмд эерэг нөлөөллийг түгээсэн, уриалсан байх гэсэн шаардлагуудын хүрээнд бүтээлийг шалгаруулан шагнаж урамшуулахаар бэлтгээд байна. Уралдаанд шалгарсан бүтээлийг дүүргийн www.bagakhangai.ub.gov.mn веб сайтад байршуулан дүүргийн авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглахаар төлөвлөсөн болно. | 70 |
| | | 1.4.Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх | -Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх;<br>-Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх;<br>-Олон нийтэд түгээсэн байх. | 2, 3 дугаар улиралд | 2-оос доошгүй | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх | 2.1."Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх | -Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх;<br>-Сонгосон чиглэлд олон нийтийг хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх;<br>-Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах;<br>-Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх. | Жилдээ | 1-ээс доошгүй | | Тус дүүрэгт олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалтад нийцэх Иргэний нийгмийн байгууллага болон Төрийн бус байгууллага байхгүй байна. Тус заалтыг хэрэгжүүлэх боломж нөхцөлийг өөр эх үүсвэрээс судалж байна. | - |
| | | 2.2.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх | -Салбарт бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгаа гаргасан байх;<br>-Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх;<br>-Үр дүнг тооцож, тайлагнасан байх. | Жилдээ | 1-ээс доошгүй | | Дүүргийн хэмжээнд нийт 43 төрийн бус байгууллага бүртгэлтэй байна. Үүнээс идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 8 төрийн бус байгууллага байгаагаас Ахмадын хороо, Улаанзагалмай хороо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо гэсэн 3 байгууллагатай 91,0 сая төгрөгийн "Санхүүжилт олгох гэрээ" байгуулан, дүүргийн Засаг даргаар батлуулан хамтран ажиллаж байна. Тус гэрээнд авлигаас ангид байх авлигыг мэдээлэх гэсэн 2 заалтыг тусгуулав. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2.3.Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах | -2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх;<br>-Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, холбогдох арга хэмжээг авах;<br>-Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх. | Жилдээ | 12-оос доошгүй нээлттэй мэдээлэх | | Дүүрэгт улс, нийслэл, ОНХС, дүүргийн төсвөөр 2024 онд нийтдээ 11.4 тэр бум төгрөгийн 22 төсөл хөтөлбөр арга хэмжээ хэрэгжиж нийт гүйцэтгэл эхний хагас жилийн байдлаар 43 хувьтай байна. Үүнд: улсын төсвийн хөрөнгөө 4, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 12, дүүргийн төсвийн хөрөнгөөр 11, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4, он дамжсан 2 ажил байна.<br>Хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөр арга хэмжээний нээлттэй ил тод байдлын хүрээнд шилэн дансны сайтад болон дүүргийн сайтуудад нийт 41 мэдээ нийтлээд байна. Үүнд: худалдан авах төлөвлөгөөг 5, сарын мэдээ тайланг 6, худалдан авах ажиллагааны тайлан 6, тендерт оролцогчдын мэдээлэл 18, үнэлгээний хороонд оролцогчдын ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг 6 нийтлэв. | 70 |
| | | 2.4.Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших | -Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах;<br>-Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших;<br>-Иргэд, олон нийтээс Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх. | Жилдээ | 2-оос доошгүй | | Авлигатай тэмцэх газарт " .... төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ ..." гэх хуулийн заалтыг хэрэгжүүлэхгүй, төрийн байгууллагын ёс зүй, хүнд суртал гаргаж байгаа тухай нэр бүхий иргэнээс гомдол ирүүлснийг шийдвэрлэн Авлигатай тэмцэх газар хүргүүлэн ажиллалаа. Судалгаагаар нийт 63 авто тээврийн хэрэгсэл дүүргийн аж ахуйн нэгж байгууллагуудын нэр дээр бүртгэлтэй байгаагаас 55 авто тээврийн хэрэгсэл буюу 100% /ашиглах боломжгүй 8 авто тээврийн хэрэгслийн судалгааг өмчийн харилцааны газарт хүргүүлсэн/ ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаартай болсон байна. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | 3.Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 3.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах | -Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах;<br>-Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх;<br>-Хэрэгжилтийг тайлагнах. | Жилдээ | 4-өөс доошгүй | | Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоол, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024 оны Хамтран ажиллах гэрээний дагуу Төрийн цахим үйлчилгээ буюу "Хурдан" цэгийн үйлчилгээг 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс хорооны зохион байгуулагч, нийгмийн ажилтан нар хариуцан үйл ажиллагааг нь тогтмолжуулаад байна.<br>Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн, "Хурдан" цэгийн үйлчилгээг хороодод шилжүүлснээр иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэж нэг цэгээс олон төрлийн үйлчилгээ, мэдээлэл лавлагааг авах боломж нөхцөл бүрдээд байна. Тайлангийн хугацаанд нийт 20 төрлийн лавлагаа, мэдээллийг 386 иргэнд үзүүллээ.<br>Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй 5 "Ш" ажиллагааны хүрээнд дүүрэгт зохион байгуулагдаж байгаа "Шүүр", "Шил", "Шүгэл" ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаар сэтгэл ханамжийн судалгааг 6 сард иргэдээс авахаар судалгааны төслийг бэлтгээд байна. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.2.Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх | -Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших;<br>-Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх;<br>-Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх. | Жилдээ | Тухай бүр | | Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулах ажлын хүрээнд "Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын дуу, дүрсний бичлэгийг ашиглах" журмыг 5 бүлэг 17 заалттай боловсруулан хамт олны хурлаар хэлэлцүүлэн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/64 дүгээр тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2024 онд Засаг даргын Тамгын газрын хяналтын камерын тоног төхөөрөмжийг 1 давхарт буулган суурилуулах ажлыг судалж 2025 оны төсвийн төсөөлөлд тусгуулахаар бэлтгээд байна.<br>Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 03/263 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүсэлт хүргүүлэн хамтран ажиллав. Хүсэлтийн хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 30-ний өдөр "Авлигын тухай ойлголт, хор хөнөөл", "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", "Авлигын гэмт хэрэг" цахим сургалтын дүүргийн ЗДТГ, харьяа хэлтэс албад, орон нутгийн өмчит газруудын албан хаагчдад зохион байгуулан 49 албан хаагчийг хамруулаа.<br>Авлигатай тэмцэх газраас 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны "Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах" тухай 2024 оны 5 дугаар тогтоолын анхаарах асуудал цахим сургалтад дүүргийн нутгийн захиргааны байгууллага болон салбар байгууллагын 6 ЭБАТ-ыг хамруулаа.<br>2024 онд дүүргийн Засаг дарга болон удирдлагуудад авлига, албан тушаалын зөрчилтэй холбоотой гомдол мэдээлэл ирүүлээгүй болно. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.3.Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх | -Төлөвлөгөөний 1.1-3.2 дахь хэсэгт заасан арга хэмжээтэй агуулгаараа давхцахгүй байх;<br>-Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээний онцлогт тохируулан зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх;<br>-Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх;<br>-Үйлчилгээ авдаг, хамтарч ажилладаг, зорилтот бүлэгт урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийсэн өөрчлөлт, хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл хүргэсэн байх. | Жилдээ | 1-ээс доошгүй арга хэмжээ | | Тус дүүрэг нь авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинэ санал, санаачилга гарган 2024 оныг "Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх жил" болгон зарлаж зорилтот жилийн хүрээнд "ФОКУС" ярилцлага бүлгийн уулзалтыг 2024 оны 04 дүгээр сарын 03, 04-ний өдрүүдэд зохион байгууллаа.<br>Уулзалтаар салбар бүрийн үйл ажиллагааны онцлогт тулгуурлан төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд чирэгдэлгүй хурдан шуурхай нээлттэй ил тод хүргэх зорилгоор ХАМТРАН АЖИЛЛАХ гэрээг 4 бодлогын хүрээнд 11 чиглэлээр байгуулан гэрээний хүрээнд авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>Гэрээ байгуулагдсанаар байгууллага хоорондын уялдаа холбоог сайжирч, ажлын бүтээмж, үр дүнг нээлттэй ил тод байдлаар иргэдэд мэдээлэх, тулгарч буй хүндрэл бэрхшээлийг хамтран туулах нөхцөл боломж бүрдсэн байна. Ярилцлагад дүүргийн 25 аж ахуйн нэгж, байгууллага, малчин болон мал бүхий иргэд, худалдаа үйлчилгээний байгууллагын төлөөлөл оролцов. | 90 |
| | | 3.3.1. Нийслэлийн хэмжээнд Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах | -Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>-Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг тусгасан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | | | Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлтэй 2023 онд танилцан, санал өгч ажилласан болно. | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.3.2.Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөлөөс авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, ёс зүйн зөрчлийн чиглэлээр боловсруулж буй дүрэм журмын төсөлд санал тусгасан байх | -Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас санал авч, нэгтгэн хүргүүлсэн байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | | | Тус арга хэмжээ зохион байгуулагдаагүй болно. | - |
| | | 3.3.3.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийх | -Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;<br>-Дүгнэлт зөвлөмж гаргасан байх. | Жилдээ | | | Нийслэлийн Засан даргын 2023 оны А/727 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2024 оны А/62 дугаар захирамжаар 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан хороодын ажилд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд удирдамжийн дагуу 19 шалгуур үзүүлэлтээр зөвлөн туслах ажлыг зохион байгуулан 8 чиглэлээр 30 зөвлөмж чиглэлийг хүргүүлээд байна. | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.3.4.Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулах | -Эх үүсвэрийн тоог нэмэгдүүлж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг сайжруулж, 7 хоног тутам мэдээ, мэдээллийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудад танилцуулах. | Жилдээ | | | 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар иргэдээс нийт 79 өргөдөл ирснээс 73 өргөдлийг хуулийн хугацаанд, 6 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлт 92%-тай, дундаж хугацаа 4 хоног 8 цаг 23 минут байна.<br>Өргөдөл, гомдлыг агуулгаар нь авч үзвэл ажилд орохыг хүссэн өргөдөл 26 буюу 34,67%, шагнал урамшууллын тухай 13 буюу 17,33%-ыг эзэлж байна. Нийслэлийн Засаг даргын А/91 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд 2021-2023 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/03 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, тайлан мэдээг нэгтгэн, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлэв.<br>Өргөдөл, гомдлын талаарх мэдээ мэдээллийг иргэдэд хүргэх, сурталчлах зорилгоор 1, 2 дугаар хороо болон Засаг даргын Тамгын газрын байранд "Өргөдөл, гомдлын мэдээлэл" самбар байршуулан, өргөдөл, гомдол хүлээн авах албан хаагчийн мэдээлэл, өргөдөл хүлээн авах эх үүсвэр, өргөдөл гаргахад шаардагдах мэдээллийн жагсаалт, удирдлагуудын иргэдтэй хийх уулзалтын хуваарийг тус тус байршуулав. Мөн дүүргийн веб сайт болох www.bagakhangai.ub.gov.mn сайтад тайлан мэдээг тухай бүр байршуулж байна. Байгууллагын угтах үйлчилгээнд өргөдөл гомдлын мэдээллийг иргэдэд хүргэх дэлгэц байршуулж, өргөдөл, гомдлын явцын мэдээллийг тогтмол хүргэж хэвшээд байна. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.3.5.Нийслэлийн удирдах ажилтны шуурхай хуралдаанаар өгсөн үүрэг даалгавар, Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах | -Засаг даргын захирамж, ажлын хэсэг, албан тушаалтанд өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцсон байх. | Жилдээ | | | 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн нийт 50 үүрэг даалгаврын хэрэгжилтийг ННЗБ-уудын дотоод удирдлагын ERP системийн ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ дэд системд хяналт хийж, үнэлж дүгнэв. Тайлангийн хугацаанд хянагдсан үүрэг даалгаврын дундаж хэрэгжилт 88,9 хувьтай байв.<br>Нийслэлийн Засаг даргын 2024 оны эхний хагас жилийн захирамжийн дүүрэгт хамааралтай заалтыг хяналтад авч биелэлтийг нэгтгэн хүргүүлэхээр бэлтгэж байна. | 70 |
| | | 3.3.6.Худалдан авах ажиллагааны А3 сургалтад хамрагдах албан хаагчийн тоог нэмэгдүүлэх | -Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо. | Жилдээ | | | А-3 сертификаттай сургалтын цахим системд шинэчлэл хийгдэж байгаатай тул сургалтыг 3 улиралд зохион байгуулахаар хойшлуулав. | - |
| | | 3.3.7.Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах | -Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг хэрэгжилтийг хангаж, төрийн сангийн үйл ажиллагаанд хяналтыг тогтмол хийж хэвшсэн байх. | Жилдээ | | | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Засаг даргын орлогч 2 орон тоотой байхаас 1 орон тоог цомхотгосон. Түүнчлэн дүүргийн ИТХ-ын даргын Зөвлөх, Засаг даргын Зөвлөхийн орон тоо зэрэг 2 албан тушаалтныг цомхотгон үндсэн цалин болон нэмэгдэл урамшууллын зардлаас 45,7 сая төгрөгийн хэмнэлт гарган ажилласан.<br>Дүүргийн төсвийн байгууллагуудын төсвийн төслийн саналыг төсвийн тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хууль, дээд газраас ирүүлсэн чиглэлийн дагуу боловсруулан НЗДТГ-ын СТСХ-т хянуулан ажиллаж байна. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.3.8.Нийслэл, дүүргийн төрийн албан хаагч нарт ёс зүйн сургалт зохион байгуулах | -Төлөвлөгөөт сургалтыг зохион байгуулж, албан хаагч нарыг хамруулсан байх. | Жилдээ | | | Засаг даргын Тамгын газрын 2023 оны А/58 дугаар тушаалаар байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүдийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө, дэгийг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.<br>Ёс зүйн дэд хороо нь албан хаагчийн ирүүлсэн гомдол мэдээллийн дагуу 5 удаа хуралдаж, дүгнэлтийг 3 удаа гарган гомдол гаргагч болон байгууллагын удирдлагад тухай бүр танилцуулан ажиллав.<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль 2023 оны 05 дугаар сарын 04-өөс хэрэгжин эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг 2024 оны 05 дугаар сарын 20-24-ний өдрүүдэд албан хаагчдад танилцуулан гарын үсэг зуруулан баталгаажуулан ажиллав.<br>Мөн хороодын албан хаагчдад Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 03/375 дугаар албан бичгээр хүргүүлэн ажиллалаа. | 30 |
| | | 3.3.9.Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын засаглал, зохион байгуулалтын бүтцийг оновчтой тогтоох, үр ашгийг нэмэгдүүлэх,нээлттэй компани болгох, ур чадвар бүхий менежментийн багийг ажиллуулах | -Олон нийтийн хяналтыг нэмэгдүүлсэн байх. | Жилдээ | | | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг дүүргийн хэмжээнд судалж, санал, дүгнэлт боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын орлогч Б.Болормаагаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав.<br>Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй Багахангай тохижилт, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж, Илч-Орд ОНӨААТҮГ-уудын өмчийн мэдээллийг НЗДТГ-ын Үйлчилгээний нэгдсэн төвийн Төрийн үйлчилгээ шийдвэрлэлтийн хяналтын ажилтан Г.Халиунд UB ERP-ээр хүргүүлэн ажилласан. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.3.10.Ёс зүйтэй, шударга өрсөлдөх орчныг бүрдүүлж, цэвэр, тунгалаг бизнесийг дэмжин хөгжүүлэх | -Шинэчилсэн журам, захирамжийн тоо | Жилдээ | | | Дүүргийн Засаг даргын 2017 оны А/19 дүгээр захирамжаар "Өрсөлдөөн хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөл"-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, худалдаа үйлчилгээний байгууллагын үйлчилгээнд иргэд, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн гомдол, саналыг шуурхай шийдвэрлэх, холбогдох дээд шатны байгууллагад шийдвэрлүүлэхээр уламжлан ажиллаж байна.<br>Тайлангийн хугацаанд Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас ирүүлсэн хэрэглэгчийн эрхийг хамгаалах 2 төрлийн гарын авлагыг иргэдэд хүргэн өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг сурталчлах, мэдээ мэдээллийг тухай бүр хүргэх зорилгоор хороодод мэдээллийн самбар, иргэдийн санал хүсэлтийг авах хайрцаг байршуулаад байна.<br>2024 онд иргэд, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн гомдол, санал ирүүлээгүй байна. | |
| НИЙТ | | | | | | | | **81.3** |

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.ОТГОНЖАРГАЛ

НЭГТГЭСЭН:
ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ,
ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Н.БАТЦЭНГЭЛ